

Номлогчийн бурханлаг дуудлага

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн
Ахлагч Рональд А.Разбанд

Чадварлаг залуу эрэгтэй хүн бүр номлолд үйлчлэх Бурханы бошиглогчийн дуудлагад зохистой байх шийдвэр гаргаж, өнөө оройноос эхлэн өөрийгөө бэлтгэх нь Их Эзэнд хэрэгтэй байна.

Эрхэм хүндэт санваартан ах нартаа оройн мэнд хүргэе. Өнөө орой би номлогчийн үйлчлэлийн талаар ярихыг хүсэж байна. Миний хэлэх зүйлс дэлхий нийтээр хуран цугласан Аароны санваартан залуу эрэгтэйчүүдийн агуу том арми, мөн тэднийг харж хамгаалдаг аав, өвөө санваартны удирдагчдад чиглэгдэж байна.

Номлогчийн ажлын сэдэв нь Их Эзэний томилсон “Өөрийн очихоор яваа хот, газар бүрд Өөрийнхөө өмнө илгээсэн” Далын найман Чуулгын гишүүн бүрийнхтэй адил бидний зүрх сэтгэлд ойрхон юм.¹ Номлогчийн ажил нь Сүмийн амин чухал хэсэг бөгөөд үүний захиасыг хүлээн авсан бүх хүмүүст амьдралыг аврах адислал болдог.

Эзэн хүмүүний дунд үйлчилсэн үед, Тэрээр Галилын тэнгист загасчдыг тороо орхин Өөрийг нь дага хэмээн дуудан, ийн хэлдэг: “Би та нарыг хүмүүсийн загасчин болгоно гэв.”² Их Эзэн энэхүү дуудлагыг даруу хүмүүнд өгсөн тул, тэднээр дамжуулан бусад хүмүүс Түүний сайн мэдээний үнэний талаар сонсож, Түүн уруу ирэх боломжтой болно.

1837 оны зургадугаар сард, Бошиглогч Иосеф Смит, Төлөөлөгч Хибер С.Кимбаллыг Англи улсад номлолд явуулахаар дуудсан билээ. Көртландын Ариун Сүмд тэд хоёул сууж байх үед Ахлагч Кимбаллын дуудлага ирсэн бөгөөд Иосеф бурханлаг эрх мэдлээр: “Хибер ах аа, Их Эзэний Сүнс надад шивнэн хэллээ: “Миний үйлчлэгч Хибер Англи уруу яван мөн миний сайн мэдээг тунхаглан, тэр үндэстэнд авралын үүд хаалгыг нээж өгөг”³ гэжээ.

Тэрхүү Сүнсний шивнэлт нь номлогч нарыг хөдөлмөрийн талбарт нь илгээхэд Их Эзэний үйлчлэгчдэд дуудлага нь хэрхэн ирдгийн жишээ юм.

Өнөөдөр Бурханы бошиглогчоос үйлчлэх бурханлаг дуудлагатайгаар, мөн адил захиасыг хүргэхээр номлогчид Их Эзэний томилолтоор хоёр хоёроороо урагш одож байна. Бидний бошиглогч, Ерөнхийлөгч Томас С.Монсон үйлчлэхээр дуудагдсан хүмүүсийн талаар:

“Амьдралд ганц олох номлогч байх боломж та нарынх. Мөнх амьдралын адислалууд та нарыг хүлээж байна. Санваарын үйлчлэлд ажиглагч биш харин оролцогч байх аз завшаан та нарт оногдсон юм” гэж хэлжээ⁴

Аароны санваартан хөвгүүд ээ, энэ боломж та нарынх шүү. Та нар бэлэн байж үүргээ биелүүлэх хүсэлтэй байна уу? Чадварлаг залуу эрэгтэй хүн бүр номлолд үйлчлэх Бурханы бошиглогчийн дуудлагад зохистой байх шийдвэр гаргаж, өнөө оройноос эхлэн өөрийгөө бэлтгэх нь Их Эзэнд хэрэгтэй байна.

Хүүхдүүдийн маань хоёр нь бүрэн цагийн номлогчоор үйлчлэх дуудлагаа авахад манай гэр бүлийн мэдэрсэн агуу баяр баяслыг би санаж байна. Тэд хоёулаа Бурханы

бошиглогчоос ирсэн тэрхүү онцгой захидлыг задлахад сэтгэл нь догдлон хөдөлж, итгэл найдвар бидний зүрх сэтгэлд бялхан байж билээ. Охин Жиниса маань Мичиганы

Детройтын номлолд, хүү Кристен маань Оросын Өмнөд Москвагийн номлолд үйлчлэхээр дуудагдсан байлаа. Яг нэг үед юутай даруухан, юутай сэтгэл догдлом агшин байсан гээч!

Хэдэн жилийн өмнө Разбанд эгч бид хоёр Нью-Йоркийн Хойд Нью-Йорк Номлолыг удирдаж байхдаа, би Нью-Йоркд ирж байгаа номлогчдыг хараад тэднээр бахархан биширдэг байлаа.

Номлолд ирсэн анхны өдөр нь бид, номлогчидтой ярилцлага хийхэд хүн бүрд баярлан талархах гайхалтай зүйл байдаг байв. Манай номлолд үйлчлэх дуудлага нь тэдэнд, мөн

тэдний номлолын ерөнхийлөгч байсан надад бурханлагаар өгөгдсөнийг би мэдэрдэг байсан.

Биднийг номлолын үүрэгт ажлаа дуусгасны дараа, Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли намайг Сүмийн Далын гишүүнээр үйлчлүүлэхээр дуудав. Шинэ Ерөнхий эрх мэдэлтнээр бэлтгэгдэх миний сургалтын эхний хэсэг нь энэ агуу Сүмийн гурван зуу гаруй номлолын нэгэнд номлогч нарыг томилоход Арванхоёрын гишүүдтэй хамт хуралдах явдал байлаа. Ерөнхийлөгч Хенри Б. Айрингийг Арванхоёрын Чуулгын гишүүн байхад хэдэн жилийн өмнө надад тохиолдсон нэг онцгой үйл явдлыг би түүний дэмжлэг, зөвшөөрлөөр та нарт ярихыг хүсч байна. Төлөөлөгч бүр хаант улсын түлхүүрүүдийг эзэмшин, эдгээр түлхүүрүүдийг Сүмийн Ерөнхийлөгчийн удирдлага, даалгаврын дагуу ашигладаг. Ахлагч Айринг номлогч нарыг хөдөлмөрийнх нь талбарт хуваарилж байсан бөгөөд энэ нь миний сургалтын нэг хэсэг байсан болохоор энэ ажлыг ажиглахад намайг урьсан юм.

Би цуглаанд зориулан хэдэн том компьютерийн дэлгэц бэлэн болсон өрөөнд нэг өглөө эрт Ахлагч Айрингтай нэгдэв. Мөн тэр өдөр бидэнд туслахаар хуваарилагдсан Номлолын Албаны нэг ажилтан тэнд байлаа.

Эхлээд, бид өвдөг сөгдөн цугтаа залбирав. Ахлагч Айринг чин сэтгэлийн үгсийг хэрэглэн номлогчдыг хааш нь хуваарилах ёстойг “төгс” мэдэж авахад өөрийг нь адислахыг Их Эзэнээс гуйсныг би санаж байна. “Төгс” гэсэн үг нь тэр өдөр Ахлагч Айрингийн харуулсан итгэлийн тухай ихийг өгүүлсэн юм.

Ажил эхлэхэд, хуваарилах хэрэгтэй номлогчийн зураг нэг компьютерийн дэлгэцэн дээр гарч ирлээ. Номлогч болгоны зураг гарч ирэхэд, номлогч бидэнтэй хамт өрөөнд байгаа юм шиг санагдаж билээ. Тэгээд дараа нь Ахлагч Айринг эелдэг уриалгахан, хайрын дуугаар:

“Өглөөний мэнд Ахлагч Раер, Өглөөний мэнд Янг эгч. Өнөөдөр сайн байна уу?” гэж мэндлэв.

16

Номлогчид хаана номлолоо дуусгах хэрэгтэй вэ гэдгийг оюун ухаандаа тунгаан бодох дуртай хэмээн тэрээр надад хэлж билээ. Энэ нь номлогчид хаана хуваарилагдахыг мэдэхэд түүнд тусалдаг байв. Тэгээд дараа нь Ахлагч Айринг номлогч нэг бүрийн талаарх бишоп, гадасны ерөнхийлөгчийн санал дүгнэлт, эмнэлгийн бичиг, бусад зүйлсийг уншиж судалдаг байв.

Дараа нь тэр дэлхий даяарх номлол, бүсүүдийг харуулсан өөр нэгэн дэлгэц уруу очив.

Эцэст нь, тэрээр Сүнсээр өдөөгдсөнөөр, тухайн номлогчийг хөдөлмөрийнх нь талбарт хуваарилж байлаа.

Их Эзэний Төлөөлөгчид дэлхий даяар үйлчлэх олон номлогчийг хуваарилах үед долоо хоног бүр энэ нийтлэг арга барил хэвшил болон тогтсон зүйл гэдгийг би Арванхоёрын бусад гишүүдээс сурч мэдсэн юм.

Олон жилийн өмнө би төрсөн нутгийнхаа Зүүн Муж улсын Номлолд номлогчоор үйлчилсэн бөгөөд энэ туршлага миний зүрх сэтгэлд гүнзгий нөлөөг үзүүлсэн юм. Бас номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн учир, Нью-Йоркд миний хүлээж авсан номлогчид илчлэлтээр надад илгээгдсэнийг мэдэх нэмэлт гэрчлэлийг зүрх сэтгэлдээ хүлээн авсандаа би баяртай байлаа.

Ахлагч Айринг хэдэн номлогчийг хуваарилсны дараа, тодорхой нэг номлогчийн талаар тунгаан бодоод над уруу эргэн харж: “Разбанд ах аа, та энэ номлогчийг хаашаа явах ёстой гэж бодож байна?” гэж асуув. Би давхийн цочиж билээ. Би Ахлагч Айрингд, мэдэхгүй

байна. Бас мэдэж чадна гэдэг ч юу л бол гэж аяархан хэлэв!. Тэр над уруу эгцлэн хараад:
“Разбанд ах аа, бүр сайн анхаар. Тэгвэл та ч бас мэдэж чадна” гэж энгийнээр хэлэв.

Үүнийг сонсоод би сандлаа Ахлагч Айрингийн компьютерийн дэлгэц уруу ойртуулан
суугаад анхаарлаа бүр сайн төвлөрүүлээ.

Номлогчдыг хуваарилах ажил цааш үргэлжлэхэд Ахлагч Айринг над уруу ганц хоёр удаа
эргэн хараад: “За, Разбанд ах аа, энэ номлогч хаашаа явах ёстой гэж та мэдэрч байна?” гэж
асуув. Би тодорхой номлолыг нэрлэн хэлэхэд Ахлагч Айринг бодлогошронгуй байдлаар
над уруу харан: “Үгүй ээ, биш!” гэв. Тэгээд тэр дараа нь тухайн номлогчийн явах газрыг
Сүнсний өдөөлтөөр мэдрэн хуваарилж байлаа.

Номлогчдыг хуваарилах цуглаан дуусах дөхсөн үед, нэг номлогчийн зураг дэлгэцэн дээр
гарч ирэв. Бидний өмнө байгаа тэр номлогч Японд хуваарилагдах ёстой гэсэн их хүчтэй,
тэр өглөөний хувьд хамгийн хүчтэй өдөөлт надад мэдрэгдлээ. Ахлагч Айринг надаас энэ
номлогчийн талаар асууна гэж би мэдээгүй, гэвч гайхалтай нь тэр надаас асуух нь тэр. Би
төдийлөн шийдэмгий бус ч, даруухнаар: “Япон уу?” гэж түүнд хэлэв. Ахлагч Айринг тэр
даруй: “Тиймээ, тийшээ очьё!” гэхэд компьютерийн дэлгэц дээр Японы номлолууд гарч
ирэхэд, тэр номлогч Японы Саппоррагийн Номлолд явах юм байна гэдгийг би шууд мэдэж
билээ.

Ахлагч Айринг номлолын нэрийг асуугаагүй ч, нөгөөх номлогчийг Японы Саппоррагийн
Номлолд хуваарилав.

Би зүрх сэтгэлдээ маш хүчтэй нөлөөг мэдэрч, тэр номлогчийн хаашаа явах ёстойг мэдсэн
тэрхүү сүнслэг өдөөлтийг мэдрэх боломж олгосонд нь Их Эзэнд чин сэтгэлээсээ талархаж
билээ.

Уулзалтын төгсгөлд Ахлагч Айринг дэлхийд сэргээгдсэн сайн мэдээг номлохоор хуваарилагдсан номлогч нэг бүрд Аврагч хайртай гэдэг өөрийн гэрчлэлийг надтай хуваалцсан юм. Эдгээр гайхамшигтай залуу эрэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүд, ахмад номлогчид, мөн гэр бүлийн ахмад хос номлогчид хаана үйлчлэхийг Аврагчийн агуу хайраар дамжуулан Түүний үйлчлэгч нар мэддэг гэж тэр надад ярьж билээ. Номлогч бүрийг Бүхнийг Чадагч Бурхан Их Эзэнээс ирсэн илчлэлтээр, Түүний үйлчлэгчдийн нэг нь энэ Сүмд үйлчлүүлэхээр дуудан, аль нэг номлолд хуваарилдаг эсвэл дахин хуваарилдаг тухай нэмэлт гэрчлэлийг би тэр өглөө хүлээн авч билээ.

Сэргээлтийн эхэн үед маш чухал үүрэг гүйцэтгэсэн Витмер хэмээх ах дүү гуравт хэлсэн Их Эзэний үгээр дуусгая. Тэд алтан ялтсуудын гэрчүүд байсан бөгөөд тэдний гарын үсгээ зурсан гэрчлэл нь *Мормоны Ном* бүр дээр байдаг. Тэд 1829 онд Бурханы бошиглогчоор Их Эзэн Есүс Христийн сайн мэдээг номлохоор дуудагдсан анхны хэсэг номлогчдын дунд байсан юм.

Сургаал ба Гэрээний 14-р хэсгийн өмнөх үгэнд ийнхүү бичсэн байдаг: “Витмерийн хөвгүүдийн гурав нь уг ажлын жинхэнэ байдлын талаар тус бүрдээ гэрчлэл хүлээн авсан байсан хийгээд өөр өөрийнхөө үүргийн асуудалд гүнээ санаа тавих болов.”

Жон Витмер болон Бага Петр Витмерт Их Эзэн: “Чамд хамгийн үнэ цэнэтэй тэр нь юу байж болохыг мэдэхийн тулд чи надаас олон удаа хүсч байсан билээ” **хэмээн хэлжээ**⁶ Залуу эрэгтэйчүүд та нараас олон нь энэ асуултыг өөрсдөөсөө асуусан байх гэж би бодож байна. Их Эзэний хариултыг одоо сонсоцгооё.

“Мөн эдүгээ, болгоогтун, би чамд хэлж байна, чамд хамгийн үнэ цэнэтэй байж болох тэр зүйл бол сүнснүүдийг надад авчирч болохын тулд, чи тэдэнтэй хамт миний Эцэгийн хаант улсад амарч болохын тулд энэ хүмүүст наманчлалыг тунхаглах явдал болой.”⁷

Залуу анд найзууд минь ээ, амьдралын чинь энэ цаг мөчид, Их Эзэнээс ирэх номлолын дуудлага та нарын хийх ёстой хамгийн чухал ажил байх болно. Одоо бэлтгэ, зөв шударгаар амьдар, Сүмийн удирдагчид болон гэр бүлээсээ суралц. Ирэгтүн, Дэлхий дээр Бурханы Хаант улсыг байгуулахад бидэнтэй нэгдэцгээ. - Энэ “агуу учир шалтгаанд” бурханлаг томилолтоо авцгаа. ⁷ Энэ бол миний даруухан залбирал, Есүс Христийн нэрээр амен.

ЭШЛЭЛ

1. Лук 10:1.

2. Матай 4:19.

3. *Teachings of Presidents of the Church: Joseph Smith* (2007), 327.

4. Томас С.Монсон, “That All May Hear,” *Ensign*, 1995 оны 5-р сар, 49.

5. Сургаал Ба Гэрээ 15:4; 16:4.

6. Сургаал Ба Гэрээ 15:6; 16:6.

7. Сургаал Ба Гэрээ 128:22.